



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2021 оны 4 сарын 10 одер

Дугаар 42

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, 21.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2021 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сонгуулийн өрөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. Сонгуулийн автоматжуулсан системд ашиглах программ хангамж, техник хэрэгслийн ажиллагааг шалган туршиж, баталгаажуулан гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Сонгуулийн автоматжуулсан системд ашиглах программ хангамж, техник хэрэгслийн ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, шалган туршиж, баталгаажуулахыг Ажлын хэсэг /Х.Баясгалан/-т үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн үйл ажиллагааны тайланг Хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсгийн дарга /Х.Баясгалан/-д даалгасугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000085

Сонгуулийн ерөнхий хорооны  
2021 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн  
7.10 дугаар тогтоолын хавсралт

Сонгуулийн автоматжуулсан системд ашиглах программ хангамж, техник  
хэрэгслийн ажиллагааг шалган туршиж, баталгаажуулан гэрчилгээ олгох ажлын  
хэсгийн бүрэлдэхүүн

№	Хариуцах ажил	Нэр	Албан тушаал
1	Ажлын хэсгийн дарга	Х.Баясгалан	Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн захирал
2	Ажлын хэсгийн дэд дарга	Б.Давааням	Тагнуулын ерөнхий газрын ахлах ажилтан
3	Нарийн бичгийн дарга	Б.Ууганцэцэг	Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн инженер
4	Гишүүн	Б.Батсайхан	Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн Техник, үйлилгээний хэлтсийн дарга
5		Г.Очгэрэл	Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн инженер
6		А.Банзрагчдорж	Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн инженер
7		Б.Наранчимэг	Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн инженер
8		Н.Даваа	Тагнуулын ерөнхий газрын ажилтан
9		Д.Баярсайхан	Тагнуулын ерөнхий газрын ажилтан
10		Д.Болдбаатар	Тагнуулын ерөнхий газрын ажилтан
11		О.Хатанбаатар	Тагнуулын ерөнхий газрын ажилтан
12		Б.Зоригоо	Тагнуулын ерөнхий газрын ажилтан
13		M.Оролзод	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн ахлах мэргэжилтэн
14		Ц.Ган-Эрдэнэ	"Үндэсний дата төв" УТҮГ-ын Систем нэгтгэлийн хэлтсийн сүлжээний инженер